



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2022 оны 03 дугаар сарын 28

Байгууллагын нэр:

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ

Нэгжийн нэр:

Авто бааз

Албан тушаалын нэр:

Жолооч (бохир соруулах машин)

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

ЧД, 12-р хороо, Дэнжийн 1000 гудамж
169-1, 169-2, 169-3

Хөдөлмөрийн нөхцөл:

Хүнд

Онцгой нөхцөл:

Ажлын зайлшгүй шаардлагаар илүү цагаар ажиллах

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй бие засах газруудын болон био ОО-ын бохирыг соруулах, захиалгын дагуу ажил үүргийг гүйцэтгэх

Албан тушаалын зорилт:

- Тээврийн хэрэгслийг жолоодон, дуудлага захиалгын дагуу ажил үүрэг гүйцэтгэх
- Эзэмшсэн техникээ өдөр тутмын ажилд бэлэн байлган, бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллах
- Замын хуудас, дагалдах хуудсыг үнэн зөв хөтлөх
- Эрхэлсэн ажлын хүрээнд хууль тогтоомж, холбогдох стандартуудыг мөрдөж ажиллах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, хариуцан гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1. "Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ" байгуулж, машин техник эзэмших	Гэрээ байгуулсан байх	Г
	1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын зааварчлага авч, гарын үсэг зурж баталгаажуулах	Аюулгүй ажиллагааны заавар, шаардлагыг биелүүлж ажиллах	Г
	1.3. Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй нийтийн болон төвлөрсөн хогийн цэг, авто баазын бие засах газруудын бохирыг соруулах	Ажил үүргийг түргэн шуурхай гүйцэтгэсэн байдал	Г
	1.4. Баяр ёслол болон олон нийтийн арга хэмжээнүүдэд био ОО ажиллуулахад бохирыг соруулах	Ажлын гүйцэтгэл, чанараар	Г
	1.5. Соруулсан бохироо бохир татан	Орчны бохирдлоос	Г

	зайлуулдаг төвлөрсөн цооногуудад асгаж юүлэх	сэргийлэх	
	1.6.Бороо их орсон үед зарим гудамж талбайн усыг соруулах, цэвэрлэх	Ажлын гүйцэтгэл, чанараар	Г
	1.7.Шаардлагатай үед газраас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу өөр ажил үүрэг гүйцэтгэх	Үүрэг даалгаврыг бүрэн биелүүлэх	Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Хариуцсан машин техникээ өдөр тутмын ажилд бэлэн байлгаж, авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих стандартын шаардлагыг хангах	Техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан байдал	Г
	2.2.Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолоодох эрхийн үнэмлэхийг биедээ байнга авч яван, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон дүрмийг хэрэгжүүлэн замын хөдөлгөөнд оролцох	Хууль, дүрмийг биелүүлж ажиллах	Г
	2.3.Техникийн өдөр бүрийн үйлчилгээ буюу гадна талын ерөнхий үзлэг, дугуй, жолооны механизм, тоормосны систем, шатахуун, тос, шингэний түвшинг шалгаж, цэнэглэх	Өдөр тутмын үзлэгийг хийж хэвшсэн байх	Г
	2.4.Кузов, бүхээг, тэвш, суудлын бүрээсийг тогтмол цэвэрлэх, угаах, ариутгах	Эзэмшсэн тээврийн хэрэгслийн ариун цэврийг бүрэн хариуцах	Г
	2.5.Жижиг эвдрэл, гэмтлийг өөрөө засварлах, ажилд гарахгүйгээр засвар үйлчилгээ хийгдэж байгаа тохиолдолд хамт хийлцэх, оролцох	Тээврийн хэрэгсэлд техникийн засвар үйлчилгээ хийх журмыг хэрэгжүүлж ажилласан байх	Г
	2.6.Эзэмшсэн машин техникийн оношлогоо, улирлын техникийн үйлчилгээг хугацаанд нь хийлгэсэн байх		Г
	2.7.Ажил буусны дараа машинаа дараагийн өдрийн ажилд бэлэн болгож гражид тавих	Жолоочийн хариуцлагагүй байдлаас шалтгаалан техник эвдрэхгүй байх	Г
	2.8.Эзэмшсэн техникт нь газар зүйн мэдээллийн GPS систем суурьлуулсан бол горимын дагуу ажиллуулж, уг төхөөрөмжийг санаатайгаар эвдэхгүй, үйл ажиллагааг доголдуулахгүй байх	Зөрчил дутагдалгүй ажиллах	Г
	2.9.Байгууллагын тээврийн хэрэгсэл, машин механизмын эвдрэл гэмтэл, засвар, түүнд шаардагдах сэлбэг хэрэгсэлд хяналт тавих журмыг мөрдөж ажиллах	Дүрэм журмыг биелүүлж ажиллах	Г
	2.10.Өөрийн буруугаас осолд орсон үед учирсан сэлбэг материалын хохирлыг бүрэн хариуцах	Осол аваараас урьдчилан сэргийлж ажилласан байх	Г
	2.11.Гражын эмх цэгц, гал усны аюулаас сэргийлэхэд өөрөөс шаардагдах бүх зүйлийг биелүүлэх	Аюулгүй байдлыг хангаж ажиллах	Г
	2.12.Гражид машин тавихдаа диспетчер манаачид хүлээлгэн өгч, хүлээн авах	Эрсдлээс урьдчилан сэргийлэх	Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Шалгах механикаас замын хуудас авах, өдөр бүр замын хуудасны бөглөлтийг механикт шалгуулж, тулгалт хийх	Хариуцлагатай ажиллах	Г
	3.2.Замын хуудас болон дагалдах хуудсыг үнэн зөв хөтөлж, холбогдох хүмүүсээр хянуулж, баталгаажуулж, гарын үсэг зуруулсан байх	Ажлын бүтээмж дээшилсэн байх	Г
	3.3.Сар бүрийн эхний 5 өдрийн дотор замын хуудас, бусад дагалдах хуудсыг санхүүд өгч, өмнөх сарын шатахууны болон бусад	Түлш шатахууны зөрчилгүй ажилласан байх	Г

	тооцоог хийж байх		
	3.4.Тооцооны хуудсанд ажилд гарсан, ажлаас буусан цаг, явсан километрийг үнэн зөв бичиж, гарын үсэг зуруулсан байх	Анхан шатны баримтын бүрдүүлэлт үнэн зөв байх	Г
	3.5.Сэлбэг хэрэгсэл, шатах тослох материал авсан шаардах хуудсыг цаг хугацаанд нь бичиж өгөх		Г
	3.6.Гүйцэтгэсэн ажлын талаар өөрт хувийн тэмдэглэл хөтлөх	Ажлын гүйцэтгэлээ үнэлүүлэх	Г
	3.7.Автомашинны эвдрэл гэмтэлд техникийн байнгын комиссоор акт тогтоолгож, баталгаажуулсан, мөн засвар хийгдсэн тухай акт үйлдэгдсэн байх	Дүрэм журмыг хэрэгжүүлсэн байх	Г
	3.8.Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал болон бусад даатгалд даатгуулсан байх	Эрсдлээс сэргийлж ажилласан байх	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомж, холбогдох тушаал шийдвэрүүд, стандартуудыг мөрдөж ажиллах	Хууль эрх зүйн акт, дүрэм журмын хүрээнд зөрчилгүй ажилласан байх	Г
	4.2.Хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох	Дүрэм журмын хүрээнд зөрчилгүй ажилласан байх	Г
	4.3.Ажлын байрны ерөнхий шаардлагыг хангахын тулд боловсрол, ур чадвараа дээшлүүлж, ажлынхаа бүтээмжийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, санаачлагатай ажиллах	Санаачлагатай, хариуцлагатай ажилласан байдал	Г
	4.4.Цаг үеийн болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь чанартай, бүрэн биелүүлж, үр дүнг тайлагнах	Үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байдал	Г
	4.5.Байгууллагаас зохион байгуулж байгаа аливаа сургалт, олон нийтийн арга хэмжээ, цэвэрлэгээ үйлчилгээний ажил, мэдээллийн цагт бүрэн хамрагдах	Оролцооны хувиар	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА


Боловсрол		Бүрэн бус дунд болон түүнээс дээш
Мэргэжил		Мэргэжил харгалзахгүй
Мэргэшил		Жолоочийн үнэмлэхтэй, ВС ангилалттай
Туршлага		1-ээс дээш жил ажилласан
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах
	Асуудал шийдвэрлэх	-Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэнд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог -Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах -Багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх
	Бусад	-Техникийн болон авто машины бүтцийн талаар өргөн мэдлэгтэй -Кирилл болон монгол бичгийн дүрэм, бичиг, ярианы чадвартай

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Баазын ерөнхий инженер, Ашиглалтын инженер, Механик инженер	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: -Замын цагдаагийн газар -Замын хөдөлгөөний удирдлага зохицуулалтын төв -Шуурхай удирдлагын цахим төв -Лицензийн төв -УСУГ -Байгууллага, аж ахуйн нэгж, иргэд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<u>Албан тушаал:</u> Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга  (Гарын үсэг) Х.Цогцэцэг (эцэг/эхийн нэр, өөрийн нэр) <u>Албан тушаал:</u> Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн  (Гарын үсэг) Б.Нарангэрэл (эцэг/эхийн нэр, өөрийн нэр) 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан: Байгууллагын нэр: Хот тохижилтын газар ОНӨААТҮГ Шийдвэрийн огноо: 2022 оны 03 дугаар сарын 28 Дугаар: А/23	
(Тамга/тэмдэг) ДАРГА	 Б.МӨНХЦЭЦЭГ (эцэг/эх-ийн нэр, өөрийн нэр) 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр